



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ЗДТГ-ын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/25/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Э.Энхцэцэг
		Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.02.25 № 16/209

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА П.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	2020.12.31	/төгрөгөөр/ 2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>60,978,686.62</u>	<u>116,666,859.62</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>1,309,801,268.16</u>	<u>1,341,400,518.64</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>1,370,779,954.78</u>	<u>1,458,067,378.26</u>
	Нийт өр төлбөрийн дүн	<u>7,604,593.61</u>	<u>4,316,798.10</u>
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>1,363,175,361.17</u>	<u>1,453,750,580.16</u>
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>1,370,779,954.78</u>	<u>1,458,067,378.26</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	<u>973,009,771.00</u>	<u>543,470,329.00</u>
	Үйл ажиллагааны зардлын дүн	<u>476,802,713.10</u>	<u>426,335,702.70</u>
	Үйл ажиллагааны үр дүн	<u>496,207,057.90</u>	<u>117,134,626.30</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн	(160,000.00)	(28,631,097.47)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>496,047,057.90</u>	<u>88,503,528.83</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,365,247,051.33	1,365,247,051.33
	Тайлант оны үр дүн	153,106,760.77	88,503,528.83
	Эцсийн үлдэгдэл	<u>1,363,175,361.17</u>	<u>1,453,750,580.16</u>
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>354,288,884.00</u>	<u>345,987,970.00</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>346,656,784.00</u>	<u>326,568,070.00</u>
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>7,632,100.00</u>	<u>19,419,900.00</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>(5,399,000.00)</u>	<u>(19,419,900.00)</u>
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	<u>2,233,100.00</u>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		311,332,789.00
	Урсгал зардал		311,332,789.00
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		311,477,508.00
	Улсын төсвөөс санхүүжих		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		311,477,508.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх.

Эрхэм зорилго: Сумын ИТХ, Засаг дарга, байгууллага, иргэдийн хэвийн ажиллах нөхцөлийг баталгаатай ханган төрийн үйлчилгээг чанартай, шуурхай хүргэж орон нутагтаа сайн сайхан, эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэн улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэн, үйл ажиллагаагаараа үргэлж манлайлсан аймгийн тэргүүний тамгын газар байхад оршино.

Алсын хараа: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэдэд хүнд сурталгүй, аливаа чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдсан цэгцтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгоно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд шинээр гарч хэрэгжсэн.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлгэрэх сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, хөтлөх чиг үүрэг бүхий төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нь тайлант хугацаанд 2 удаа өөрчлөгдсөн байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн авлагын эцсийн үлдэгдэл дансанд тусгагдсан ажиллагчидтай холбоотой авлагын 1.8 сая төгрөгийн үлдэгдлийн 0.4 сая төгрөг, 4.3 сая төгрөгийн өглөгийн 0.6 сая төгрөгийн тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмнө оноос шилжиж ирсэн, эзэн холбогдогч нь тодорхойгүй гэсэн тайлбар өгсөн.

Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй зарим хөрөнгүүдийг сумын иргэдэд түрээслүүлж, гэрээний хугацаа 2020.10.21-ний өдрөөр дуусгавар болсон байхад түрээсийн гэрээг дахин сунгахгүйгээр ОНӨ-ийн хөрөнгийг үнэ төлбөргүй үргэлжлүүлэн түрээслүүлсэн байна.

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа НБББББ-ийг боловсруулж мөрдөөгүй байна.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 34.6 сая төгрөгийн орлого төвлөрч, зарцуулсан байна. Тус дансанд Морьтон-Эрдэнэ ХХК-аас шатахуун, ариутгалын зардалд гэж 5.0 сая төгрөгийн хандив өгсөн байх ба байгууллагын урсгал засварын зардалд 1.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 291.6 сая төгрөгийн 19 ажил гүйлгээнээс 277.1 сая төгрөгийн 18, зарлагын 24.7 сая төгрөгийн 3 ажил гүйлгээ, зардал зарцуулах тухай 41.3 сая төгрөгийн дүнтэй 10 тушаалаас 8 тушаалыг тус тус мэдээлээгүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 72.1 сая төгрөгийн 10 алдаа, зөрчил илрүүлснээс, 63.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1.4 сая төгрөгийн 4 албан шаардлага өгч, 7.0 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

Залруулсан алдаа:

1. Тайлант хугацааны элэгдлийн зардлыг 60.9 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцож тайлагнасныг залруулав.
2. Тайлант хугацаанд зарцуулсан 2.2 сая төгрөгийн автомашины сэлбэг, аж ахуйн материалыг аж ахуйн материалын дансанд үлдэгдлээр тусгасныг нярвын тайланд зарлагаар тусгуулж залруулав.

Төлбөрийн акт:

1. Сумын Засаг даргын Б/25 захирамжаар ажилтны зэрэг дэвийн нэмэгдлийг 16 хувиар үндэслэлгүй нэмэгдүүлснээс 0.5 сая төгрөг, ажилласан хоногийг илүү тооцож 0.1 сая төгрөгийн цалин тус тус илүү олгосон зөрчилд, нийт 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага:

1. Мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан зардлуудыг ангилал тус бүрээр түүвэрлэж, холбогдох анхан шатны баримтаас тулгаж үзэхэд 0.3 сая төгрөгийн зардлыг зардал хооронд шилжүүлэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан зааврын дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тухай албан шаардлага хүргүүлэв.

2. Санхүүгийн тайлангийн авлагын эцсийн үлдэгдэл дансанд тусгагдсан ажиллагчидтай холбоотой авлагын 1.8 сая төгрөгийн үлдэгдлийн 0.4 сая төгрөг, 4.3 сая төгрөгийн өглөгийн 0.6 сая төгрөгийн тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмнө оноос шилжиж ирсэн, эзэн холбогдогч нь тодорхойгүй гэсэн шалтгаанаар барагдаагүй байна.

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж, өмнө оны эзэн холбогдогч тодорхой бус авлагын үлдэгдлийг тодорхой болгож, шийдвэрлэх тухай албан шаардлага хүргүүлэв.

3. Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй зарим хөрөнгүүдийг сумын иргэдэд түрээслүүлж, гэрээний хугацаа 2020.10.21-ний өдрөөр дуусгавар болсон байхад түрээсийн гэрээг дахин сунгахгүйгээр ОНӨ-ийн хөрөнгийг үнэ төлбөргүй үргэлжлүүлэн түрээслүүлсэн байна.

- Аймгийн ИТХ-ын 2019 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан орон нутгийн өмчийн хөрөнгийн харилцааг зохицуулах журмын дагуу иргэдтэй түрээсийн гэрээ байгуулж, үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх тухай албан шаардлага хүргүүлэв.

4. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 291.6 сая төгрөгийн 19 ажил гүйлгээнээс 277.1 сая төгрөгийн 18, зарлагын 24.7 сая төгрөгийн 3 ажил гүйлгээ, зардал зарцуулах тухай 41.38 сая төгрөгийн дүнтэй 10 тушаалаас 8 тушаалыг тус тус мэдээлээгүй байна.

- Мэдээллийг нөхөн байршуулж, цаашид хугацаа хоцроох, мэдээллийг байршуулахгүй байх зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага өгөв.

Зөвлөмж:

1. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа НБББББ-ийг боловсруулж мөрдөөгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн НБББББ-ийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Морьтон-Эрдэнэ ХХК-иас шатахуун, ариутгалын зардалд гэж 5.0 сая төгрөгийн хандив өгснийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, байгууллагын урсгал засварын зардалд 1.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3. Бараа материалын ангитай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Дэлгэрэх сумын ЗДТГ-ын нэр дээр 19 хонь тоологдсон байхад байгууллагын бараа материалын мал амьтдын бүртгэлд 8 хонь, 1 бух, нийт 9 толгой мал бүртгэлтэй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-т “Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил, гүйлгээг заавал бүртгэнэ” гэсэн заалтын дагуу малын тоо толгойг бараа материалын тайланд үнэн зөв тусгаж, тайлагнах.

8.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Дэлгэрэх сумын ЗДТГ	1	1	-	-	1	-	-	-
НИЙТ									

8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Дэлгэрэх сумын ЗДТГ	10	72.1	2	63.1	1	0.6	4	1.4	3	7.0
НИЙТ		10	72.1	2	63.1	1	0.6	4	1.4	3	7.0